



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 2/158

Улаанбаатар хот

“Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар”
ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй барилга
байгууламжийг акталж, данс бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 51 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/712 дугаар захирамж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дүрэм”-ийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон нийт 91,049,809.98 (ерэн нэгэн сая дөчин есөн мянга найман зуун есөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг акталж, данс бүртгэлээс хасах, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн холбогдох өөрчлөлт хийхийг “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ (Ч.Мэндбаяр)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй барилга байгууламжийг буулгахад гарах хоёрдогч түүхий эдийн зориулалтаар ашиглаж болох материалыг худалдан борлуулж 3,784,550 (гурван сая долоон зуун наян дөрвөн мянга таван зуун тавь) төгрөгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлэхийг “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ (Ч.Мэндбаяр)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В. Оюумаа* (В.ОЮУМАА)



1150500583

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 оны сарын-ний
 өдрийн дугаар тушаалын хавсралт



АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
 БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан ГНЖ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Мэргэжлийн улсын байцаагчийн дүгнэлт	Эзэмшигч байгууллага
1	Ус дулаан дамжуулах төв-80	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	69,460,294.57	18,279,024.60	51,181,269.97	НМХГ-ын Улсын байцаагчийн 2013 оны 02- 07-92/71	"Орон сууц нийтийн аж ахуйн ОНӨААТҮГ"
2	Контторын өргөтгөл	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	18	19,363,680.00	5,378,800.20	13,984,879.80	ХСХГ-ын Улсын байцаагчийн 2023 оны 02- 13-01/026/211	
3	Цехийн барилга	Баянгол дүүрэг, 7 дугаар хороо	19	2,225,835.41	2,225,835.41	0.00		
Дүн						65,166,149.77		